



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 0/289

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/370 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Моннис моторс” ХХК-тай байгуулсан “Байгаль хамгаалагчдын техник хэрэгсэл нийлүүлэх” Багц-1 ажлын НХААГ/201901063-1 дугаартай “Автомашин нийлүүлэх”, “Номин трейдинг” ХХК-ийн Номин моторс салбартай байгуулсан Багц-2 ажлын НХААГ/201901063-2 дугаартай “Мотоцикл нийлүүлэх” гэрээний дагуу тус тус нийлүүлэгдэж буй автомашин болон мотоциклийг нийслэлийн өмчид хүлээн авах ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх автомашин болон мотоциклийг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авч, ашиглагч байгууллагад актаар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулахыг Ажлыг хэсэг /М.Энхболд/-т даалгасугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Рэнцэнбямба/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн, ашиглалт удирдлагын газрын даргын 2019 оны 0... дугаар сарын 06. өдрийн 0/2019 дугаар тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч	М.Энхболд	Нийслэлийн Өмчийн, ашиглалт удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн дарга
Гишүүд:	Т.Чингэл	Нийслэлийн Байгаль орчны газрын Захиргааны хэлтсийн Байгаль хамгаалах тасгийн дарга
	Б.Хүдэр	Нийслэлийн Байгаль орчны газрын Ойн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Мөнхбаатар	Нийслэлийн Өмчийн, ашиглалт удирдлагын газрын мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга	Б.Наранцацрал	Нийслэлийн Өмчийн, ашиглалт удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн